

## ОРОС СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ

*С.Дамдинсүрэн\**

Олон улс судлалын хүрээлэнд Орос судлалын салбар байгуулагдаад хоёр жил орчим ажиллаж байгаа хэдий ч Орос судлал нь монголын түүх судлалын салшгүй хэсэг байсаар ирсэн баялаг уламжлалтай юм. Монгол, Оросын хувь заяаг хамгийн нягт холбосон ХХ зуун хоёр орны харилцаанд нийгэм-эдийн засгийн, цэрэг улс төр, соёл, шинжлэх ухаан, боловсролын бүх талыг хамарсан гүнзгий ул мөрийг үлдээсэн билээ. Орост өнгөрсөн зуунд явагдсан хувьсгалууд, социалист нийгмийн бүтээн байгуулалтын үйл явц, ЗХНКН-ын түүх, түүний үзэл суртлын баримтлалыг судлах явдал тэр үеийн манай Орос судлалын хандлагыг тодорхойлж байв. Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхийг судлах явдал орос судлалын нэг чухал чиглэл болсон юм. Тус хоёр орны харилцааны агуулга, шинж чанар, механизмд эерэг, сөрөг нөлөө үзүүлсэн үйл явдлаар дүүрэн өнгөрсөн он жилүүдийн түүхийг бүтээлчээр судлан боловсруулах, Монгол, Зөвлөлтийн түүх судлалд зуршил болсон ерөөсгөл үнэлгээ, үзэл баримтлалыг эргэн харах, Монгол, Оросын харилцааны шинэ хандлагыг судлах шаардлага бидэнд тулгарч байна.

Ийм шаардлага нь дараах гурван гол учир шалгаантай юм. Үүнд:

**Нэгд**, урьд манай түүх судлалд социализм нь капитализмыг зайлшгүй ялах тухай, хоцрогдсон орон капиталист бус замаар социализмд хүрэх тухай, улс хоорондын харилцааны пролетарийн ба социалист интернационализмын зарчмын тухай, социалист орнуудын хөгжлийн нийтлэг зүй тогтол, ойртон нягтрах замаар коммунизмд бараг нэгэн зэрэг орох тухай гэх мэт загварчлал үзэл баримтлал ноёрхож, зөвхөн ангич зарчмын үүднээс л түүхэн үйл явдлыг үнэлж цэгнэдэг байв.

**Хоёрт**, манай харилцааны түүхийн гол чухал баримтууд нууц архивуудад хатуу чанд халгалагдаж байснаас орон судлал,

\* С.Дамдинсүрэн- ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор

ялангуяа Монгол, Оросын харилцааны түүх судлалд багагүй гажуудал, өрөөсгөл үнэлгээ, “Цагаан толбо” үлдээжээ.

**Гуравт,** социалист систем задарч, ЭЗХТЗ, Варшавын гэрээний байгууллага, ЗСБНХУ ч байхгүй болсноор улс хоорондын харилцааны хоёр туйлт бүтэц өөрчлөгдөж, хүйтэн дайны үе шувтарч, манай хоёр орон ардчилал шинэчлэл, зах зээлийн харилцаанд шилжин, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогын үзэл баримтлалаа шинээр боловсруулав. Улс хоорондын харилцааны шинэ зарчим, шинэ тулгуурууд ч бий болов.

Энэ бүхнээс өнгөрсөн түүхээ эргэж харах, шинээр судлах, үнэлэх, судалгааны онол, арга зүй, механизмд ч шинээр хандах хэрэгтэй болсон нь тодорхой байна.

Өнөөдөр Монгол, Оросын харилцааны орчин үеийн байдал хийгээд түүхийг соёл иргэншлийн үүднээс судлах явдал шинэлэг, сонирхолтой, ирээдүйтэй чиглэл болж байна. Энэ нь түүх ба эрин үеэ илүү бүрэн гүйцэд, бүх талаас нь танин мэдэж, ойлгох, тайлбарлах, улам бодитой үнэлэн цэгнэх хийгээд монгол, оросын түүхийн шинжлэх ухаанд саяхан болтол ноёрхож байсан хэт үзэл сурталжсан ангич явцуу хандлагаас үүдэлтэй урьдын дутагдлыг гэтлэн давахад шинэ өргөн бололцоо олгож байна.

XX зууны Монгол, Оросын түүхэн харилцаанд агуулга, далайц хэмжээгээрээ, цаг хугацаа, орон зайгаараа ч гол байр эзэлсэн социалист нийгэм байгуулах хамтын туршилт эцсийн дүнд амжилтгүй төгссөн ч хоёр ард түмний соёл иргэншлийн харилцан нөлөөллийн хүрээнд уламжлагдан хөгжих үнэт зүйл хуримтлагдсаар байсныг тэмдэглэх хэрэгтэй. Нийгэм улс төрийн хоёр системийн сөргөлдөөн, дайн, хувьсгалын нарийн ээдрээтэй нөхцөлийг хамтдаа туулсан Монгол, Оросын харилцаа Зөвлөлт Холбоот Улсын дэмжлэг, тусламжийн эерэг нөлөөгөөр Монгол улс тусгаар тогтнолоос бэхжүүлэн баталгаажуулж, эдийн засаг, соёлоо хөгжүүлж өвөрмөц соёл иргэншилээ хадгалж чадсан төдийгүй шинэ агуулгаар баяжуулж, тэргүүний орнуудаас алсад үлдсэн хоцрогдлоо мэдэгдэхүйц хэмжээгээр багасгаж, өнөөгийн дэлхийн хөгжлийн чиг хандлагад хөл нийлүүлж, хөгжингүй ардчилал, зах зээлийн харилцаа бүхий бүх улс оронтой нээлттэй байх хөгжлийн шинэ загварт шилжих эдийн засаг, материалын болон оюуны чадавхитай болсон билээ.

Орос судлалын чиглэлээр сүүлийн арваад жилд үндсэндээ ОХУ-ын гадаад бодлогын шинэчлэл, Ази, Номхон далайн бүс

нутагт хандсан бодлого, Зүүн, Зүүн хойт Азийн орнуудтай тогтоосон хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграц, эдийн засгийн глобалчлалын үйл явцад оролцох, Сибирь, Алс Дорнолоо хөгжүүлэх талаар боловсруулж байгаа төслүүд, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг асуудлаар голлон судалж байна. Үүний зэрэгцээгээр Монгол, Оросын харилцаа, уламжлал ба шинэчлэлийн асуудалд нилээд анхаарч шинээр нээлттэй болсон архивуудын баримт материалыг судлан эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах замаар түүхэн үнэнийг сэргээх, түүхийн “Цагаан толбо”, эзэнгүйдлийг арилгах, хоёр орны түүхийн зангилаа асуудлуудыг шинээр үнэлж цэгнэх нь тус салбарын судалгааны нэг гол чиглэл болж байна. Орос судлалын салбарын ажилтнууд энэ чиглэлээр сүүлийн арван жилд нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл 10 гаруй, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 30 гаруйг туурвиж хэд хэдэн томоохон баримтын эмхэтгэл хэвлүүлжээ. Эдгээрийн дотроос эрдэм шинжилгээний төслийн хүрээнд Б.Балдоо, С.Дамдинсүрэн, Л.Хайсандай нарын бичсэн “Монголын тусгаар тогтнол ба Оррос, Хятадын хүчин зүйл” /УББ. 1999/ нэгэн сэдэвт зохиол, тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын оролцоотойгоор Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнтэй хамтран бэлтгэсэн “Россия и Монголия: Новый взгляд на историю взаимоотношений в XX веке” /Москва, 2001 он/, Б.Лхамсүрэнгийн “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” /УБ. 1997/, О.Батсайханы “Орос улсаас Монголын талаар явуулсан бодлого” /1911-1946 он/ /УБ. 1998 он/, Ч.Батцэцэгийн “ОХУ-ын БН Буриад улс” /УБ. 1996 он/ зэрэг уншигчид, судлаачдын сонирхлыг татсан бүтээл цөөнгүй байна. Мөн О.Батсайханы эмхэтгэсэн “Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээ /өдөр тутмын тэмдэглэл/ баримт бичгийн эмхэтгэл” /УБ. 1999 он/, С.Дамдинсүрэн нарын эмхэтгэсэн “Коминтерн ба Монгол” баримтын эмхэтгэл /УБ. 1996 он/, Х.Энхтүвшин нарын эмхэтгэсэн “Монгол-Зөвлөлтийн соёл шинжлэх ухаан, техникийн харилцаа” /1921-1960 он/ баримт бичгийн эмхэтгэл /УБ. 2000 он/ зэрэг нь Монгол Оросын харилцааны түүхийг судлах сурвалж баазыг үлэмж өргөтгөснөөрөө их ач холбогдолтой юм. Манай ажилтнуудын оролцоотойгоор “БХК /б/ намын баримт бичигт Монголын тухай”- баримтын эмхэтгэл хэвлэлд бэлтгэгдэж байгаа бөгөөд 1920-1934 оныг хамарсан I боть нь энэ онц эцсээр, 1935-1952 оныг хамарсан II боть нь 2002 онд хэвлэлд шилжих

юм. Энэ нь хоёр орны харилцааны төдийгүй XX зууны Монголын түүх судлалд цоо шинэ, баялаг сурвалж болно.

Эдүгээ тус салбарын эрдэмтэд 2001-2004 онд гүйцэтгэх “ОХУ-ын бүс нутгаа хөгжүүлэх чиг хандлага ба Монгол-Оросын харилцаа” /1999-2000 он/ сэдэвт судалгааны ажил эхлээд байна. Энэ сэдэвт ажлын хүрээнд: Азид чиглэсэн ОХУ-ын бодлогын идэвхжил бүс нутгаа хөгжүүлэх үзэл баримтлал Монгол-Оросын хамтран ажиллах боломжууд, Монгол улсын хөгжлийг түргэтгэхэд Оросын оролцоог нэмэгдүүлэх, Монгол-Оросын хил орчмын бүс нутаг, субъектуудын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, хоёр улсын харилцааны механизмыг шинээр төлөвшүүлэх, боловсронгуй болгох зэрэг асуудлуудын харилцан хамаарал, харилцан шүтэлцээ, түншлэлийн зарчим, олон тулгуурт нээлттэй бодлого, дэлхийн нийтлэг хандлагын үүднээс авч үзэхийн хамт ОХУ-аас хөрш орнуудтайгаа харилцааг хөгжүүлж буй шинэ хандлага, туршлагыг ч судалж, Монгол, Оросын харилцааны түүхэнд холбогдох баримт, сурвалжийн судалгааг үргэлжлүүлэн нилээд өргөн, цогцолбор шинжтэй хамтарсан судалгаа явуулж байна.